Түгээлт: Ерөнхий

2015 оны 06 дугаар сарын 19

Эх хувь : Англи

НҮБ-ын ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ЗӨВЛӨЛ

ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ, СОЁЛЫН ЭРХИЙН ТУХАЙ ХОРОО

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай Пактын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Засгийн газрын дөрөвдүгээр илтгэлийг хэлэлцүүлсэн талаарх дүгнэлт

1. 2015 оны 6 дугаар сарын 3, 4-ний өдрүүдэд хуралдсан НҮБ-ын Эдийн засаг,нийгэм, соёлын эрхийн тухай Хорооны 26, 27 дугаар (E/C.12/2015/SR.26 and 27) хуралдаануудаар Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай Пактын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Засгийн газрын дөрөвдүгээр тайлан илтгэлийг хэлэлцэж, 6 дугаар сарын 19-ний өдөр зохиогдсон 50 дугаар хуралдаанаараа дараах дүгнэлт, зөвлөмжүүдийггаргалаа. Үүнд:

А.***Танилцуулга***

2. Хэдийгээр хугацааг хожимдуулан өргөн барьсан хэдий ч Монгол Улсын Засгийн газрын 4 дүгээр тайлан илтгэл, болон нэмэлт асуумж (E/C.12/MNG/Q/4/Add.1),цөм баримт бичиг (HRI/CORE/MNG/2013) мөн илтгэлийг хэлэлцүүлэн хамгаалсан Засгийн газрын төлөөлөгчдийн тайлбар болон нэмэлт мэдээллийг Хорооны зүгээс талархалтайгаар хүлээн авч байна.

Мөн Засгийн газрын төлөөлөгчидтэй хийсэн уулзалт маш цэгцтэй, үр дүнтэй байсныг онцлон тэмдэглэмээр байна.

Б. ***Эерэг тал***

3. Хороо нь Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пактын Нэмэлт Протоколыг Монгол Улс 2010 онд соёрхон батлсаныг талархан хүлээн авч байна.

4. Мөн Монгол Улсын Засгийн газар дараах хүний эрхийн асуудлаар олон улсын баримт бичгүүдэд нэгдэн орох буюу соёрхон батлсанд Хорооны зүгээс ихээхэн сайшаалтай байна. Үүнд:

- Албадан алга болсон хүмүүсийг хамгаалах тухай олон улсын Конвенц – 2015,
- Цаазаар авах ялыг устгах асуудлаарх Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын Нэмэлт Протокол – 2012,
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай Конвенц болон түүний Нэмэлт прокол – 2009

5. Монгол Улсын Засгийн газрын зүгээс дараах бодлогын болон хууль эрх зүйн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж буйг Хорооны зүгээс ихээхэн сайшалтайгаар хүлээн авч байна. Үүнд:

- Төлбөрийн чадваргүй яллагдагчид хууль эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай хууль – 2013,

- Хүний наймаатай тэмцэх тухай хууль – 2012,
- Сонгуулийн тухай хууль – 2012,
- Жендэрийн эрх тэгш байдлын тухай хууль /2011/ болон түүнийг хэрэгжүүлэх стратеги / 2013-2016/,
- Мэдээллийн ил тод байдал болон мэдээлэл авах эрхийн тухай хууль – 2011,
- Үндэсний хөгжлийн стратеги – 2007-2021
- Эрүүл насжилт болон ахмад настны эрүүл мэндийн асуудлаарх үндэсний хөтөлбөр – 2014-2020,
- Боловсролын асуудлаар төрөөс баримтлах бодлого – 2014

С. Зөвлөмжийн гол агуулга

Хууль эрх зүйн шинэчлэлийн хүрээнд:

6. Дотоодын хууль тогтоомжийг Пактын үзэл санаатай нийцүүлэхээр хууль эрх зүйн шинэчлэл хийгдэж байгаа боловч явц нь маш удаан бөгөөд иргэний нийгмийн төлөөлөлтэй илүү өргөн хүрээтэй зөвлөлдөх шаардлагатай гэж Хороо үзэж байна.

Иймд Хорооноос дараах зөвлөмжийн өгч байна. Үүнд:

1. *Дотоодын хууль тогтоомжийг Пактын үзэл санаанд нийцүүлэхээр хийгдэж буй хууль эрх зүйн шинэчлэлийг эрчимжүүлэх*
2. *Энэ үйл явцад иргэний нийгмийн төлөөллийг идэвхитэй оролцуулахд анхаарлаа хандуулах*

<u>Үндэсний хүний эрхийн байгууллагын хүрээнд:</u>

7. Хүний эрхийн үндэсний комиссын нөхцөл байдал сайжирсан нь сайшаалтай хэдий ч аймаг, орон нутгийн төвшинд хүрч ажиллахад комиссын төсөв санхүү дутагдалтай байгаа мөн комиссын зөвлөмжүүдийг хууль эрх зүйн бичиг баримт боловсруулахдаа тусгах явдал дутмаг байгаад Хороо анхаарлаа хандуулж байна.

Иймд Хорооны зүгээс дараах зөвлөмжийг өгч байна үүнд:

1. Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын чадавхийг бэхжүүлэх хүчин чармайлтаа үргэлжлүүлэх,
2. Парисын зарчимд нийцүүлэн Комиссын бие даасан байдлыг бүрэн хангах санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх,
3. Комиссын зөвлөмжүүдийг хууль, тогтоомж болосвруулахдаа тусгах ажлыг эрчимжүүлэх,

<u>Малчдын эрх:</u>

8. Хорооны зүгээс малчид эдийн засаг, нийгэм, соёлын эрхээ эдлэхэд нь дараах байдлаар сөрөгөөр нөлөөлж буй уул уурхайн төслүүдийн сөрөг нөлөө тэр дундаа малчид эрхээ хамгаалах хууль эрх зүйн орчин думтаг байгааг анхааралдаа авч байна. Үүнд:

А. Малчдын уламжлалт бэлчээрийн газар нутагт уул уурхайн олборлолт явагдсаны улмаас ус, хадлангийн газар болон бэлчээрийн нутаг дэвсгэр хумигдаж, тэдний эрх зөрчигдсөөр байгаад,

Б. Малчдын бэлчээрийн нутаг дэвсгарт уул уурхайн үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг олгохоосоо өмнө малчдад мэдээлж, тэдний чөлөөт сонголтод тулгуурласан зөвшөөрөл авахгүй байгаад

С. Уул уурхайн олборлолтын улмаас эрх нь зөрчигдсөн малчдад олгож буй нөхөн төлбөр нь маш хангалтгүй байгаад, /Илтгэлийн 1.2, 2.2, 11 болон 15-ийг харах/

Иймд Хорооны зүгээс дараах зөвлөмжүүдийг өгч байна. Үүнд:

1. Уул уурхайн олборлолтыг зохицуулж буй хууль эрх зүйн орчныг шинэчлэх,
2. Малчдын бэлчээр, хадлангийн газар нутаг, усны эх үүсвэрээ хамгаалах эрхийг нь хангахад чиглэсэн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нарийн хянах
3. Малчдын эрхийг хөндсөн уул уурхайн зөвшөөрөл олгохоосоо өмнө тэдэнтэй учир утгатай, үр дүнтэй оролцоог ханган зөвлөлдөж байх
4. Малчдад зохих ёсны нөхөн олговрыг олгож байх.
5. Уул уурхайн олборлолтын улмаас эрх нь зөрчигдсөн малчдад эрхээ хамгаалж гомдол гаргах үнэ өртөг нь тохиромжтой, хүртээмжтэй гомдол барагдуулах механизмыг бүрдүүлэх,

<u>Уул уурхай ба орчны хамгаалалт</u>

9. Хороо нь уул уурхайн салбарт байгаль орчныг хамгаалах бодлого хангалтгүй байгаад, хоорондоо зөрчилтэй байгаа одоогийн хууль, тогтоомжууд болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдэхгүй байгаад анхаарлаа хандуулж байна.

Иймд Хорооны зүгээс дараахь зөвлөмжүүдийг өгч байна. Үүнд:

1. *Нэн түрүүнд байгаль орчныг хамгаалах болон уул уурхайн салбартай холбоотой хууль тогтоомжийг шинэчлэх,*
2. *Энэ хүрээнд үндэстэн дамнасан корпорацууд болон бусад бизнестэй холбоотой хүний эрхийн асуудлаар байгуулагдсан Ажлын Хэсгээс өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд анхаарах хэрэгтэй /2013/.*
3. *Уул уурхайн олборлолтын зөвшөөрлийг олгохоосоо өмнө хүний эрхийн болон байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх,*
4. *Уул уурхайн олборлолтын улмаас эрх нь хөндөгдөх бүх талуудыг нөлөөллийн үнэлгээ хийх үйл явцадүр дүнтэй оролцуулах,*

<u>Нийтийн эрх ашгийг шүүхээр хамгаалах, шүүхийн хүртээмж</u>

10. Хорооны зүгээс хөдөө орон нутаг дахь хуулийн зөвлөгөө өгөх төвүүдийн хүртээмж болоннийтийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагууд шүүх болон Үндсэн хуулийн цэцэд нэхэмжлэл гаргах боломж хязгаарлагдмал байгаад анхаарлаа хандуулж байна. /2-р зүйл, параграф-1/. *Иймд Хорооны зүгээс дараах зөвлөмжүүдийг өгч байна. Үүнд*

1. *Хуулийн зөвлөгөө өгдөг төвүүд тэр дундаа хөдөө орон нутаг дахь төвүүдийн хүний нөөцийн чадавхийг бэхжүүлж, санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх,*
2. *Төрийн бус байгууллагуудад нийтийн эрх ашиг, ялангуяа эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хамгаалах тохиолдолд шүүх болон Үндсэн хуулийн цэцэд нэхэмжлэл гаргах эрхээр хангах,*

<u>Авлига</u>

11. Засгийн газрын зүгээс авлигын эсрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байгаа боловч Хороо нь Монголд гарч буй авлига тэр дундаа шүүх засаг болон төрийн албан дахь авлигын асуудалд анхаарлаа хандуулж байна /2,1-р зүйл/.

Иймд *Хорооны зүгээс дараах зөвлөлөөг өгч байна. Үүнд:*

1. *Авлига тэр дундаа шүүх засаглал болон төрийн албан дахь авлигатай тэмцэх арга хэмжээ 2 дахин нэмэгдүүлэх,*
2. *Төрийн зүгээс байгууллагуудын бие даасан байдал болон ил тод байдлыг баталгаажуулах*
3. *Авлигын тохиолдлуудыг шалгаж, авлигын эсрэг хуулийн хэрэгжилтийг хангах ажлаа эрчимжүүлэх,*
4. *Авлигыг үл тэвчих бодлогыг хэрэгжүүлж, шүүгчид, прокурорууд болон цагдаа нарт хууль хэрэгжүүлэх үүргийг нь сайтар ухааруулах чиглэлээр арга хэмжээ зохион байгуулах,*
5. *Авлигын эсрэг үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн, мэдээлэл өгсөн хүмүүс, ялангуяа хохирогч, гэрчүүд болон тэдний хуульчдын хүний эрхийг хамгааллыг баталгаажуулах*.

***<u>Үл ялгаварлан гадуурхалт</u>*:**

12. Үндсэн хууль болон бусад хуульд үл ялгаварлах зааалтууд байгаа хэдий ч бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, хөгжлийн бэрхшээл г.м. бүх үндэслэлийг багтаасан ялгаварлан гадуурхалтын эсрэг цоuц хууль тогтоомж байхгүй (2.2-р зүйл) байгаад Хороо сэтгэл зовниж байна.

Иймд Хорооны зүгээс дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Хороо нь бүх хүн эдийн засаг, нийгэм, соёлын эрхээ эдлэхийг нь хангах, эрхээ эдлэхэд нь бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, хөгжлийн бэрхшээлийг багтаан ялгаварлан гадуурхах хориотой бүх үндэслэлээр ялгаварлан гадуурхахыг хориглосон цогц хамгаалах хуультай болохыг гэрээний талд зөвлөмж байна. Хороо нь тус хорооноос гаргасан Эдийн засаг, нийгэм, соёлын эрх дээр үл ялгаварлах ерөнхий зөвлөмж дугаар 20 (2009)-г гэрээний талд сануулж байна.

<u>Лесбиян, гей, бисексуал, трансжендэр, интерсекс хүмүүсийн эсрэг ялгаварлан гадуурхалт</u>

13. Хороо нь гэрээний талын шинээр боловсруулж буй Эрүүгийн хууль болон Хөдөлмөрийн хуулийн төслүүдэд бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаагаар ялгаварлахыг хориглосон үндэслэлээр оруулсныг сайшааж байна. Хэдий тийм ч хөдөлмөр эрхлэлт, орон байр, эрүүл мэнд, боловсролын салбарт ЛГБТИ хүмүүсийн эсрэг ялгаварлан гадуурхалт үргэлжилсээр байгааг цохон тэмдэглэж байна. Цаашлаад хороо нь ижил хүйсийн хосуудыг хүлээн зөвшөөрөхгүй байгаа нь энэхүү пактын 2-р зүйлийн 2-т заасны дагуу эдлэх ёстой эрхээ хосууд эдлэж чадахгүй байгаа байдалд сэтгэл зовниж байна.

Хорооны зүгээс дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна. Үүнд:

1. ЛГБТ хүмүүс хүйсийн чиг баримжаанаасаа хамааран ялгаварлан гадуурхагдахгүй байх чиглэлээр бүхий л арга хэмжээг авах тэр дундаа олон нийтийн ойлголтыг сайжруулах чиглэлээр ажиллах,
2. Ижил хүйсийн хосууд эдийн засаг, нийгэм, соёлын эрхээ эдлэх адил тэгш эдлэх асуудлыг нь хүлээн зөвшөөрөх,

<u>Эрэгтэй эмэгтэй хүний эрх тэгш байдал</u>

14. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль /2011/ болон түүнийг хэрэгжүүлэх стратегийг батлан хэрэгжүүлж байгаа нь сайшаалтай хэдий ч гэр бүл болон нийгэмд оршиж буй эрэгтэй, эмэгтэй хүний ялгаатай үүрэг, хариуцлагын талаарх уламжлалт ойлголт байсаар байгаад Хороо анхааралдаа авч байна.

Мөн УИХ болон шийдвэр гаргах төвшний албан тушаалд эмэгтэйчүүд бага төлөөлөлтэй байна. Түүнчлэн, ажлын зар дээр хүйсээр ялгаварлан гадуурхдаг, ажлын байран дээрх бэлгийн дарамт болон цалин багатай салбарт эмэгтэйчүүд голчлон ажиллаж байгаа зэрэг асуудлуудад Хороо анхаарлаа хандуулж байна. /3 болон 7 дугаар зүйл/

Хорооны зүгээс дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

1. Эрэгтэй эмэгтэй хүний үүрэг хариуцлагын талаар ойлголт нэмэгдүүлэх үндэсний хэмжээний компанит ажил болон түр тусгай арга хэмжээг зохион байгуулах
2. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхээ эдлэхэд эрэгтэй эмэгтэй хүний эрх тэгш байдлыг хангах чиглэлээрх хүчин чармайлтаа нэмэгдүүлэх,
3. Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулж, хяналт тавин гарсан үр дүнг нь дараагийн тайланд тусгах
4. Хүйсээр нь ялгаварлан гадуурхдаг ажлын байрны зар тавих явдлыг нэн даруй зогсоох,
5. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг батлах,
6. Ажлын байран дээрх хүйсийн тэгш байдлыг хангах, ажлын байран дээрх бэлгийн дарамтыг арилгахад чиглэсэн хууль эрх зүй болон захиргааны шаардлагатай арга хэмжээнүүдийг авах,
7. Хөдөлмөр эрхлэлтийн хүрээнд хүйсийн тэгш байдлыг хангах үүднээс эрчүүд давамгайлсан ажлуудад эмэгтэйчүүд ажиллах явдлыг хөхиүлэн дэмжих

<u>Ажилгүйдэл</u>

15. Эдийн засаг хурдацтай өсөж байгаа боловч ажилгүйдлын төвшин өндөр тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, малчид, залуучуудын ажилгүйдлын төвшин илүү өндөр байгаад Хороо анхаарлаа хандуулж байна. /6-р зүйл/.

Иймд Хорооноос дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

1. *Ажилгүйдлын төвшинг бууруулах чиглэлээр эрчимтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх,*
2. *Эдийн засгийн өсөлт бүх салбарт тэгш явагдахад анхаарах,*
3. *Ингэхийн тулд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, малчид, залуучууд зэрэг ажилгүйдэлд илүү өртөмтгий бүлэгт чиглэж,*
4. *Хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох хуулиудын хүрээнд хэрэгжүүлж буй тусгай арга хэмжээ болон зорилтот хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг сайжруулах,*
5. *Ажил олгогчдыг дэмжих зэрэг бусад арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх*

Бичил уурхай эрхлэгчид

16. Малаа алдсан олон малчид гар аргаар алт олборлож, бичил уурхай эрхэлж буй бөгөөд энэ нь ихэнх тохиолдолд хууль бус,мөнгөн ус зэрэг химийн хортой бодис ашигладаг, орлого багатай, ажлын байрны аюултай нөхцөлд үйл ажиллагаа явуулж байгаад Хорооны зүгээс анхаарлаа хандуулж байна.

Иймд Хорооноос дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

1. *Монгол Улсын Засгийн газрын зүгээс гар аргаар алт олборлогчид, бичил уурхай эрхлэгчдийн эрхийг хамгаалах,*
2. *Хууль эрх зүйн зохистой орчин бүрдүүлэх зэргээр шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх,*
3. *Уул уурхайн олборлолтонд мөнгөн усны үлдэгдэлгүй баяжуулах цех ажиллуулах зохицуулалтыг эрчимжүүлэх,*
4. *Гар аргаар алт олборлогчид, бичил уурхай эрхлэгчийг уул уурхайн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл болон олборлолтын газар авах боломжийг бүрдүүлэх,*
5. *Тэдний үйл ажиллагааг хуульчлахад шаардлагатай байгаа татварыг бууруулах зэргээр шаардлагатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх,*

Хөдөлмөрийн нөхцөл

17. Хэдийгээр эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны талаарх стандартуудыг сайжруулах чиглэлээр хууль эрх зүйн үүднээс арга хэмжээ авч байгаа боловч зам барилга, эрчим хүч, уул уурхайн салбарын аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандарт маш хангалтгүйгээс үүдсэн ослын улмаас нас барах тохиолдол гарч байгаад Хорооны зүгээс анхаарлаа хандуулж байна. Мөн хөдөлмөрийн байцаагчдын тоог нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзэж байна. /7-р зүйл/.

Хорооны зүгээс дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

1. *Хөдөлмөр, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны талаарх хууль, эрх зүйн баримт бичгүүдийн хэрэгжилтийг сайжруулах,*
2. *ОУХБ-ын хөдөлмөрийн хяналт, шалгалтын асуудлаарх 81 болон 129 дүгээр Конвенцуудыг соёрхон батлах зэргээр шаардлагатай баримт бичгүүдийг батлах, дагаж мөрдөх,*
3. *Мөн бэлтгэгдсэн хөдөлмөрийн байцаагчдын тоог нэмэгдүүлж, улс орон даяар тэгш хуваарилан ажиллуулах,*

Хүүхдийн хөдөлмөрийн мөлжлөг

18. Хорооны зүгээс хөдөө орон нутаг, хөдөө аж ахуй болон хувийн салбар дахь хүүхдийн хөдөлмөр эрхлэлт оршсоор байгаад, тэр дундаа уул уурхайд ажиллах, морь унах зэрэг аюултай, хортой хөдөлмөрийгхүүхэд эрхэлж буйд анхаарлаа хандуулж байна. /10-р зүйл/.

Иймд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна. Үүнд:

1. *Хүүхдийн хөдөлмөрийг шалган илрүүлэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр идэвхитэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх,*
2. *Хүүхдээр аюултай, хортой хөдөлмөр эрхлүүлэхийг хориглох,*

3. *Морь унах насны доод хязгаарыг олон улсын стандартад нийцүүлэн нэмэгдүүлэх зорилготой Засгийн газрын 107 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх,*
4. *Хортой, хүнд нөхцөлд хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн асуудлыг шийдвэрлэх хүчин чармайлтаа хоёр дахин нэмэгдүүлэх*.

<u>Эвлэлдэн нэгдэх эрх</u>

19. Хорооньуул уурхайн компанийн ажилчид эвлэлдэн нэгдэх үйл ажиллагаанд оролцсоныхоо төлөө ажлаасаа халагдах эрсдэлтэй тулгардаг бөгөөд эвлэлдэн нэгдэх эрх сайн хангагдаагүй байгаад анхаарлаа хандуулж байна. /8-р зүйл/.

Иймд дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

1. *Хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн шинэчилсэн найруулгын төсөлд эвлэлдэн нэгдэх эрхийг хангахтай холбоотой зүйл заалт оруулахад анхаарах*
2. *Тэдгээрийн хэрэгжилтийг сайтар хангах,*

<u>Нийгмийн хамгаалал</u>

20. Хороо нь улс орны хэмжээнд нийгмийн хамгааллын бодлого хөтөлбөрүүд бүх нийтийг хамарч төдийлөн чадахгүй байгаад тэр дундаа одоогийн нийгмийн хамгааллын хөтөлбөрүүд нь хамгийн ядуу хүсүүстээ төдийлөн хүрч чадахгүй байгаад анхаарлаа хандуулж байна. Түүнчлэн, нийгмийн хамгааллын тэтгэмжүүд нь хангалттай бус байгаад анхаарлаа хандуулж байна. /9-р зүйл/

Иймд Хорооны зүгээс нийгмийн хамгааллын тогтолцооны шинэчлэлийг яаралтай дуусгаж, нийгмийн хамгааллын асуудлаарх бодлогын хэрэгжилтийг хангахдаа үл ялгаварлан гадуурхах зарчим дээр тулгуурлан хамгийн эмзэг бүлэгт чиглүүлэхийг зөвлөж байна. Энэ хүрээнд:

1. *Нийгмийн түнш болон эрх эдлэгчидтэй сайтар зөвшилцөх*
2. *Нийгмийн халамжийн тэтгэмжүүдийг амьжиргааны төвшинтэй уялдуулж, халамж хүртэгчид болон тэдгээрийн гэр бүлийн амьжиргааг хангахад хүрэлцэхүйц байхаар тогтоох,*
3. *Хорооноос 2008 онд нийгмийн хамгаалал хүртэх эрхийн талаар өгсөн 19-р зөвлөмж, ОУХБ-ын 202 дугаар зөвлөмж, "Нийгмийн хамгаалал хүртэх эрх, болон тогтвортой хөгжлийн зорилтын чухал хэсэг бол – нийгмийн хамгааллын суурь хэм, хэмжээ" /2015/ хэмээсэн Хорооны мэдэгдэлтэй уялдуулан нийгмийн хамгаалал хүртэх эрхийг хэрэгжүүлэх үүрэгээ биелүүлэх хүрээнд Нийгмийн хамгааллын суурь хэм хэмжээг тогтоох,*
4. *ОУХБ-ын нийгмийн хамгааллын доод хэм, хэмжээний талаарх 102 дугаар Конвенцид нэгдэн орох асуудлыг эрчимжүүлэх,*

<u>Эмэгтэйчүүд, хүүхдийн эсрэг хүчирхийлэл</u>

21. Хэдийгээр хууль эрх зүйн болон бусад холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа боловч эмэгтэйчүүд, хүүхдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсээр байгаад Хорооанхаарлаа хандуулж байна. Түүнчлэн, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хүрээнд шийдвэрлэгдсэн зөрчилт тохиолдлуудын тоо цөөхөн, уг хуулийн талаарх олон нийтийн ойлголт сул мөн хүчирхийлэлд өртсөн хохирогчдыг хамгаалах байр, үйлчилгээний хүртээмж хангалтгүй байгаад анхаарлаа хандуулж байна.

Иймд Хорооны зүгээс дараах зөвлөмжүүдийг өгч байна. Үүнд:

1. *Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангахад дорвитой арга хэмжээ авч хэрэгжүүлэх*
2. *Хүчирхийлэл үйлдэгчдэд зохих ялыг оноох,*
3. *Хөдөө орон нутаг, алслагдсан бүс нутаг дахь хамгаалах байрны тоог нэмэгдүүлэх,*
4. *Иргэний нийгмийн байгууллагын үйл хэргийг дэмжих зэргээр хохирогчдод үзүүлэх дэмжлэг, хамгааллыг сайжруулан баталгаажуулах,*
5. *Мөн шүүх байгууллагын албан хаагчид, хууль хэрэгжүүлэгчид, нийгмийн ажилтнуудад эмэгтэйчүүдийн эрх болон Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн талаар сургалт зохион байгуулах,*

<u>Ядуурал</u>

22. Сүүлийн жилүүдэд эдийн засгийн өсөлт хурдацтай явагдаж байгаа боловч ядуурлын түвшин нэмэгдэж, эмэгтэйчүүд, хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон алслагдсан бус нутагт амьдардаг малчид ихээр өртөж байгаад Хороо анхаарлаа хандуулж байна. Түүнчлэн, төрийн байгууллагуудын уялдаа холбоо сул, хэрэгжүүлж буй хөтөлбөрүүд нь уялдаагүйн улмаас ядуурлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд нь төдийлөн үр дүнд хүрэхгүй байгаад Хороо анхаарлаа хандуулж байна. /2 болон 11 дүгээр зүйл/

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай Пакт /2001 онд/ болон ядуурлын талаарх Хорооны мэдэгдэлтэй холбогдуулан Хорооны зүгээс дараах арга хэмжээг хэрэгжүүлэхийг зөвлөж байна. Үүнд:

1. *Ядуурлыг бууруулахад эдийн засгийн өсөлтийг давуу тал болгон ашиглах арга хэмжээ авч хэрэгжүүлэх,*
2. *Уул уурхайн үйлдвэрлэлийн орлогыг монгол хүн бүр тэгш хүртэх нөхцлийг хангах,*
3. *Хүний эрхийн зарчимд тулгуурласан үндэсний ядуурлыг бууруулах стратегийг батлан тодорхой хугацаанд хүрэх зорилтууд, хянах шалгуур үзүүлэлт бүхий хэрэгжүүлэх механизмыг тодорхойлж, түүнийг аймаг сумдын хөгжлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх*,
4. *Ядуурлыг бууруулах стратегийг голлон хэрэгжүүлэх яамыг тодорхойлж, хяналт үнэлгээ болон тайлагналтын зохистой механизмыг тодорхойлж хэрэгжүүлэх*,

<u>Тохитой орон байраар хангагдах</u>

23. Хороо нь өсөн нэмэгдэж буй дотоод шилжих хөдөлгөөнөөс үүдэлтэй хот орчмын бүсийн албан бус суурьшилт мөн түүний улмаас үүсэж буй орон байрны дутагдалтай байдал нь амьдрах орчныг доройтуулж, иргэдийн суурь үйлчилгээ авах нөхцлийг хомсдуулж байгаад анхаарлаа хандуулж байна. Түүнчлэн, Хороо нь “Гэр хорооллын дахин төлөвлөлтийн зохицуулалт” нь газраа албан ёсоор өмчлөөгүй иргэдийг албадан нүүлгэх, тэдгээр хүмүүст хангалттай хэмжээний нөхөн төлбөр олгогдохгүй байх, эсвэл нийгмийн халамжийн суурь үйлчилгээ хүртэх нөхцөл бүрдээгүй бүсрүү нүүлгэх гэх мэтээрхүмүүсийн амьдралд сөрөг нөлөө үзүүлж байгаад анхаарлаа хандуулж байна. /11 дүгээр зүйл/.

Тохитой орон байраар хангагдах талаарх Хорооны 1991 оны 4-р ерөнхий санал, албадан нүүлгэлтийн талаарх 1997 оны зөвлөмжийг дахин дурьдан, дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

1. Хот суурин газар албан бусаар суурьшиж буй хүмүүсийн тоог багасгах,
2. Эмзэг бүлгийн иргэдэд зориулсан халамжийн орон сууцыг нэмэгдүүлэх хүчин чармайлтаа хоёр дахин нэмэгдүүлэх,
3. Дунд хугацаанд, гэр хорооллын амьжиргааны нөхцөл байдлыг сайжруулах, цэвэр ус, ариун цэвэр, эрүүл ахуйн хүртээмжтэй орчин, боловсрол болон эрүүл мэндийн үйлчилгээ зэрэг нийгмийн суурь үйлчилгээ боломжийг сайжруулахад дорвитой арга хэмжээ авах,
4. “Гэр хорооллын дахин төлөвлөлтийн зохицуулалт”-д гэр хорооллын хүмүүсийн тохитой орон байранд амьдрах эрхэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх, тухайн газарт түрээсээр амьдарч буй иргэдийг хамгаалах, албадан нүүлгэхээс хамгаалах, нөхөн төлбөрийг хангалттай олгуулах, нийгмийн суурь үйлчилгээ хүртэх боломжтой бүсрүү нүүлгэн суурьшуулах асуудлуудыг баталгаажуулсан нэмэлт өөрчлөлт оруулах,
5. Албадан нүүлгэлтийн талаарх олон улсын стандартад нийцүүлсэн хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх,

<u>Зохистой хоол, хүнсээр хангагдах эрх</u>

24. Хороо нь монголчуудын дундах шим, тэжээллэг хүнсний бүтээгдэхүүний тэнцвэртэй бус хуваарилалт, мөн хөндлөнгийн лабораториудад хүнсний аюулгүй байдл болон хүнсний ногоонд их хэмжээний пестицид агуулагдаж байгаа тухай мэдээллийг олон нийтэд мэдээлэхийг хориг тавьсанд анхаарлаа хандуулж байна. Мөн хүнсний талоны үнэ маш бага болон хуваарилалт нь хязгаарлагдмал байгаад анхаарал хандуулж байна. /11-р зүйл/.

Хорооны зүгээс дараахи зөвлөмжийг өгч байна. Үүнд:

1. Таргалалт болон зүрх судасны өвчинтэй тэмцэх зорилгоор эрүүл хооллолтын талаарх үйл ажиллагаагаа эрчимжүүлэх,
2. Өртөг нь боломжийн, аюулгүй, зохистой хүнс тэжээлээр хангах хүчин чармайлтаа хоёр дахин нэмэгдүүлэх,
3. Хоол, хүнсний дутагдал, өлсгөлөнтэй тэмцэх арга хэмжээгээ эрчимжүүлэх,
4. Хүнсний талон хөтөлбөрт хамрагдах шаардлагатай өрх гэрийг бүрэн хамруулж, тэдэнд шаардлагатай шим тэжээл, илчлэгийг хангахуйц хүнсний бүтээгдэхүүнийг хүнсний талоноор дамжуулан олгох,
5. Улсын хүнсний лабораториудын хүний нөөц болон техник, технологийг сайжруулах замаар тэдгээрийн хараат бус байдлыг бэхжүүлэх,
6. Төрийн бус лабораторуудын хүнсний аюулгүй байдлын талаарх мэдээллийг олон нийтэд мэдээлэхэд тавьсан хоригийг арилгах,
7. Хоол, хүнсэн дэх пестицидийг шалгах, илрүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр эрчимтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх,
8. Хорооноос 1999 онд зохистой хоол, хүнсний талаар өгсөн ерөнхий саналыг хэрэгжүүлэхэд анхаарлаа хандуулах
9. Дэлхийн хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас 2004 онд гаргасан зохистой хоол, хүнсээр хангагдах эрхийг дэвшилттэйгээр хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх сайн дурын удирдамжийг хэрэгжүүлэхэд анхаарлаа хандуулах,

Ус ба эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн орчноор хангагдах эрх

25. Хороо нь ундны цэвэр ус, болон эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн орчноор хангагдах эрх нь хот, хөдөөд ялгаатайбайгаад анхаарлаа хандуулж байна. Мөн гэр хорооллын бүсэд усны үнэ өндөр байгаад болон уул уурхайн олборлолт хөрс, усны бохирдол үүсгэж байгаад анхаарлаа хандуулж байна. /11 болон 12 дугаар зүйл/.

Хороо нь усаар хангагдах эрхийн талаар өгсөн 2002 оны 15 дугаар ерөнхий санал болон эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн орчны талаарх Хорооны мэдэгдлийг эргэн дурьдаж, дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

1. Хот, хөдөөгийн хүн амын ундны ус болон эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн орчноор хангагдах эрхийн зөрүүтэй байдлыг арилгах,
2. Ундны цэвэр усны үнийг хүн бүрт хүртээмжтэй үнээр хүргэх,
3. Уул уурхайн олборлолтын улмаас үүсэж буй хөрс, усны бохирдолтой тэмцэх ажлыг хоёр дахин эрчимжүүлэх

Агаарын бохирдол ба эрүүл мэнд

26. Хороо нь Улаанбаатар хотын гэр хорооллын бүсийн агаарын бохирдлын төвшин нэмэгдэж буйд анхаарлаа хандуулж байна. Мөн үүнээс үүдэн амьсгалын зам, зүрх судас, уушгины өвчлөл нэмэгдэж буй ихээхэн анхаарлаа хандуулж байна./11, 12 дугаар зүйл/. Иймд дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

1. Агаарын бохирдлын төвшинг бууруулах талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх,
2. Улаанбаатар хот, гэр хорооллын иргэдийн эрүүл мэндийг сайжруулахад дорвитой арга хэмжээ авч хэрэгжүүлэх,
3. Эрчим хүчинд хэмнэлттэй халаалтын системийг гэр хорооллын бүсэд нэвтрүүлэх,

ХДХВ/ДОХ болон бусад өвчин

27. Хороо нь Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ болонХДХВ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад холбогдох бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангалтгүй байгаа зэргээс үүдэн ХДХВ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх арга хэмжээ тун хязгаарлагдмал байгаад болон ХДХВ/ДОХ-ыг илрүүлэх тестийг албадан өгүүлж буйд анхаарлаа хандуулж байна. Мөн тодоррхой арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа боловч архины хэтэрсэн хэрэглээнээс үүдэлтэй элэгний хавдар, гепатит В болон Ц вирусын тархалт өндөр байгаад анхаарлаа хандуулж байна. /12 дугаар зүйл/.

Иймд Хорооноос дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна. Үүнд:

- ХДХВ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх,
- ДОХ-ын асуудлаарх Үндэсний хороо байгуулах,
- Холбогдох хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг эрчимжүүлэх,
- ХДХВ/ДОХ-ыг илрүүлэх шинжилгээг сайн дурын, нууц байлгах асуудлаар шаардлагатай хууль эрх зүйн болон бусад холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх,

- Архинд донтолтын талаар компанит аян өрнүүлэх замаар архинд донтолттой тэмцэх арга хэмжээг эрчимжүүлэх,
- Элэгний В болон С вирусээс урьдчилан сэргийлэх болон эмчлэх арга хэмжээгээ хоёр дахин эрчимжүүлэх,

<u>Боловсрол эзэмших эрх</u>

28. Хороо нь 6-11 насны хүүхдийн 5 орчим хувь нь бага сургуульд хамрагдаагүй байгаад, сургуулиас завсардсан хүүхдүүдийн ихэнх хувь нь хөдөө орон нутгийн, үндэсний цөөнхийн болон эрэгтэй хүүхдүүд эзэлж байгаад анхаарлаа хандуулж байна. Мөн анги хэт дүүргэлт, сургуулийн барилга байгууламж, дэд бүтцийн хангалтгүй байдал болон Улаанбаатарын сургуулиудын боловсролын чанар муудаж байгаа талаарх тайлан илтгэлд анхаарлаа хандуулж байна /13, 14 дүгээр зүйл/.

Иймд Хороо дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

1. Бүх хүүхдүүд сургуульд хамрагдах боломжийг бүрдүүлэх
2. Хүүхдүүдийн тэр дундаа хөдөө орон нутгийн, үндэсний цөөнхийн хүүхдүүд болон эрэгтэй хүүхдүүдийн сургууль завсардалтын гол шалтгааныг тодорхойлж, завсардалтыг багасгах чиглэлээр дорвитой арга хэмжээ авч хэрэгжүүлэх,
3. Шинэ сурууль барих, сургалтын материаллаг орчныг сайжруулах, багш боловсон хүчнийг сургах зэргээр Улаанбаатарын хүүхдүүдийн боловсролд хамрагдах эрхийг баталгаажуулахад хангалттай хөрөнгө зарцуулах,
4. Эцэг эхчүүдийн дунд боловсролын чухал байдлын талаар аян зохион байгуулах

<u>Хамран сургалт</u>

29. Хороо нь маш олон сургуулиуд тэр дундаа алслагдсан хөдөө орон нутаг дахь сургуулиад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд хүртээмжтэй бус байгаагаас тэд боловсрол эзэмших боломж бүрдэхгүй байгаад анхаарлаа хандуулж байна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах багш нар дутагдалтай байгаад анхаарлаа хандуулж байна /2.2, 13, 14 дүгээр зүйл/.

Иймд Хорооноос дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хамран сургалтанд хамрагдах нөхцлийг сайжруулах. Үүний тул

А. Багш нарт хамран сургалтын талаар албан ёсны сургалт зохион байгуулах

Б. Оюутанд зориулсан хувь хүний сургалтын төлөвлөгөө боловсруулах

В. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ээлтэй сургуулийн орчинг буй болгох

Г. Эдгээр асуудлуудыг шийдвэрлэхэд хангалттай хөрөнгө, мөнгө зарцуулах

<u>Соёлын эрх</u>

30. Хороо нь хөрөнгө мөнгөний хомсдлын улмаас хэрэгжилт нь хангалтгүй байгаа Урлаг соёлын талаарх үндэсний бодлогын хэрэгжилтэнд анхраалаа хандуулж байна. Хэдийгээр энэ чиглэлээр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа боловч соёлын өвийг хадгалах, хамгаалах асуудалд мөн анхаарлаа хандуулж байна. /15 дугаар зүйл/.

Иймд Хороо дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна. Үүнд:

1. Урлаг соёлын асуудлаарх Үндэсний бодлогын хэрэгжилтийг сайжруулахад шаардлагатай хөрөнгө мөнгийг зарцуулах,
2. 2014 оны Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хяналтыг сайжруулах замаар соёлын өвийн хадгалалт, хамгаалалтанд оруулах хөрөнгө оруулалтаа нэмэдүүлэх, энэ чиглэлээрх хүчин чармайлтаа сайжруулах,

<u>Бусад зөвлөмж</u>

31. Хороо нь Цагаач иргэд, тэдгээрийн гэр бүлийн гишүүдийг хамгаалах тухай олон улсын Конвенц болон Хүүхдийн эрхийн тухай Конвенцийн Мэдээлэл харилцааны журмын тухай Нэмэлт протоколд нэгдэн орохыг зөвлөж байна.

32. Хороо нь Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай Пакт, түүний Нэмэлт Протокол болон түүний шүүхэд хэрэглэгдэх байдлын тухай ойлголт нэмэгдүүлэх арга хэмжээг шүүхийн албан хаагчид, хуульчид, эрх эдлэгчдэд зохион байгуулах ажлыг эрчимжүүлэхийг зөвлөж байна.

Мөн Пактын зүйл заалтуудыг дотоодын хууль тогтоомжиндоо ашиглах талаар 1998 онд өгсөн Хорооны 9 дүгээр ерөнхий саналын хэрэгжилтийг хангахад анхаарлаа хандуулахыг зөвлөлөө.

33. Хороо нь Пактын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Засгийн газрын 4 дүгээр тайлан илтгэлд өгсөн энэхүү зөвлөмжийг Монгол хэлрүү хөрвүүлж, УИХ-ын гишүүд, төрийн албан хаагчид, шүүх засаглалын албан хаагчид зэрэг нийгмийн бүхий л төвшний албан хаагчдад хүргэн, тэдгээрийг хэрэгжүүлэхэд авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийг Пактын хэрэгжилтийн талаарх дараагийн илтгэлдээ оруулж Хороонд мэдээлэхийг зөвлөж байна.

Мөн энэхүү зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэдтөрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллагын оролцоог сайтар хангахыг зөвлөж байна.

34. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай Пактын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Засгийн газрын 5 дугаар тайлан илтгэлийг 2020 оны 6 дугаар сарын 30 гэхэд Хороонд өргөн барихыг зөвлөж байна

Мөн Олон улсын хүний эрхийн гэрээний (HRI/GEN/2/Rev.6, chap. I) тайлан илтгэлийн талаарх гарын авлагын хэсэгт заасаны дагуу Засгийн газрын зүгээс тайлангийнхаа цөм баримт бичгийг өөрчлөн, сайжруулахыг зөвлөж байна.